

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/140/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakhd@audit.gov.mn](mailto:narmandakhd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Материаллаг байдал .....	13
3.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ТАЗАР

7 дугаар баг, Харлан сум, Дорнод аймаг, 21000  
УТТ-ын 0 байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 263

Танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ЧОЙБАЛСАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Г.БАТСЭНГЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилго, 3 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга 86.3 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

011022101

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>350,344,203.35</b>	<b>525,601,053.35</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,671,898.00	6,671,898.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	6,671,898.00	6,671,898.00
3352	Хувь хүмүүсээж авах авлага	6,671,898.00	6,671,898.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	343,672,305.35	518,929,155.35
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,465,000.00	14,465,000.00
35110	Тусгай зориулалттай материал	14,465,000.00	14,465,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	104,473,355.35	279,730,205.35
35410	Бяниг хэргийн материал	3,302,380.00	3,302,380.00
35420	Аж ахуйн материал	67,503,756.85	160,132,256.85
35430	Сэлбэг хэрэгсэл	-	1,120,000.00
35440	Түлц, шатах тослох материал	270,000.00	171,850.00
35470	Бусад хангамжийн материал	33,397,218.50	115,003,718.50
35600	Мал амьтад	224,733,950.00	224,733,950.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,438,879,471.45</b>	<b>4,644,492,281.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,438,879,471.45	4,644,492,281.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,369,556,271.45	2,573,769,081.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	672,574,874.18	745,946,442.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	(82,950,955.14)	(107,340,465.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	162,145,946.04	162,145,946.04
39204	Хуримтлагдсан элэгдэл	(55,918,445.91)	(88,158,506.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,332,090.28	131,386,700.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,909,972.63)	(56,962,937.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,296,010.00	27,296,010.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,612,682.33)	(21,623,832.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,331,377,638.88	2,524,524,832.64
39215	Хуримтлагдсан элэгдэл	(682,778,231.92)	(853,116,609.20)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	109,221,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,069,323,200.00	2,070,723,200.00
39301	Програм хангамж	4,832,200.00	4,832,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,782,200.00)	(4,082,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,068,273,200.00	2,069,973,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>4,789,223,674.80</b>	<b>5,170,753,334.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>13,297,170.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	13,297,170.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	13,297,170.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	13,297,170.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	13,297,170.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,789,223,674.80</b>	<b>5,157,456,164.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	470,742,769.00	470,742,769.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,017,815,200.00	2,017,815,200.00
51101	Өмч: - төрийн	2,017,815,200.00	2,017,815,200.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,186,342,988.56	2,554,575,478.13
51210	Өмнөх үеийн үр дүн	2,186,342,988.56	2,186,342,988.56
51220	Тайланг үеийн үр дүн	-	368,232,489.57
51300	Хөрөнгийн дахин үнэлээний зөрүү	114,322,717.24	114,322,717.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>4,789,223,674.80</b>	<b>5,170,753,334.37</b>

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,980,073,633.68</b>	<b>1,722,918,950.17</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,394,388,199.68</b>	<b>716,952,162.17</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,394,388,199.68	702,007,162.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,394,388,199.68	702,007,162.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	588,500.00	85,884,000.41
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	228,413,000.00	15,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,165,386,699.68	600,013,161.76
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	14,945,000.00
122001	Хандив тусламж /догоод/	-	14,945,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>585,685,434.00</b>	<b>1,005,966,788.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	62,439,634.00	56,637,288.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,097,500.00	120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,277,634.00	27,476,082.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,064,500.00	29,041,206.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	523,245,800.00	949,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	523,245,800.00	949,329,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>960,652,378.81</b>	<b>1,354,686,460.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>805,439,418.81</b>	<b>1,339,457,744.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	796,047,341.24	1,226,303,665.40
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	399,281,950.35	635,174,802.22
210101	Үндсэн цалин	257,378,745.72	344,582,146.38
210102	Нэмэгдэл	104,739,376.63	219,737,655.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,906,000.00	19,722,000.00
210104	Урамшуулал	27,257,828.00	51,133,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,480,308.52	73,891,064.17
210201	Тэтгэврийн даатгал	34,560,870.61	51,499,632.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,070,242.08	5,950,453.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,249,382.65	2,975,376.38
210204	Ажилгүйдлийн даатгал	745,281.38	2,819,604.24
210205	Эрүүл мэндийн даатгал	7,854,531.80	10,645,997.16
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,459,374.56	23,708,987.41
210301	Гэрэл, цахилгаан	13,485,084.56	18,535,487.41
210302	Түлш, халаалт	8,974,290.00	5,173,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,741,214.00	67,961,383.41
210401	Бичиг хэрэг	3,432,300.00	3,597,318.00
210402	Тээвэр, шатахуун	22,332,154.00	54,844,108.41
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	1,533,780.00	1,638,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,819,600.00	7,881,957.00
210408	Бараа материал акалсны зардал	31,623,380.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	960,000.00	7,543,720.00
210502	Хоол, хүнс	-	7,543,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	960,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,931,000.00	3,483,500.00
210604	Урсгал засвар	9,931,000.00	3,483,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,742,000.00	23,804,000.00
210702	Догоод албан томилолт	9,242,000.00	23,804,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	500,000.00	-

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,639,022.00	1,424,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлгэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	538,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	173,350.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,840.00	89,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	29,832.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	240,812,471.81	389,311,518.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,240,094.00	153,979,456.00
210903	Үндсэн хөрөнгийн элдгэд, хоргодол	180,572,377.81	235,332,062.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,392,077.57	113,154,079.20
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	650,000.00	39,902,168.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,827,572.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	12,274,596.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	8,742,077.57	73,251,911.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,742,077.57	73,251,911.20
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>155,212,960.00</b>	<b>15,228,716.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	155,212,960.00	15,228,716.00
223001	Бусад хөрөнгө	155,212,960.00	15,228,716.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,019,421,254.87</b>	<b>368,232,489.57</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	237,819,721.68	-
225001	Үндсэн хөрөнгө худалдааны гарз	237,819,721.68	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(237,819,721.68)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>781,601,533.19</b>	<b>368,232,489.57</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>814,686,934.00</b>	<b>1,069,730,788.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>229,001,500.00</b>	<b>63,764,000.41</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	229,001,500.00	63,764,000.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	229,001,500.00	63,764,000.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	588,500.00	48,764,000.41
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	228,413,000.00	15,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>585,685,434.00</b>	<b>1,005,966,788.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	62,439,634.00	56,637,288.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчин бус этгээдээс авсан хандив, тусламж	11,097,500.00	120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,277,634.00	27,476,082.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,064,500.00	29,041,206.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	523,245,800.00	949,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	523,245,800.00	949,329,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>610,088,555.00</b>	<b>1,038,251,702.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>610,088,555.00</b>	<b>1,038,251,702.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>600,696,477.43</b>	<b>925,097,623.21</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,953,848.35	629,917,238.22
210101	Үндсэн цалин	264,050,643.72	339,324,582.38
210102	Нэмэгдэл	104,739,376.63	219,737,655.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,906,000.00	19,722,000.00
210104	Урамшуулал	27,257,828.00	51,133,000.00

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,480,308.52	73,891,064.17
210201	Тэтгэврийн даатгал	34,560,870.61	51,499,632.69
210202	Тэтгэмжийн даатгал	4,070,242.08	5,950,453.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,249,382.65	2,975,376.38
210204	Ажилгүйдлийн даатгал	745,281.38	2,819,604.24
210205	Эрүүл мэндийн даатгал	7,854,531.80	10,645,997.16
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,459,374.56	30,538,007.41
210301	Гэрэл, цахилгаан	13,485,084.56	18,535,487.41
210302	Түлш, халаалт	8,974,290.00	12,002,520.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,633,300.00	22,353,300.00
210401	Бичиг хэрэг	3,389,800.00	3,433,118.00
210402	Тээвэр, шатахуун	19,934,120.00	14,364,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,533,780.00	1,638,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,600.00	2,917,832.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,004,000.00	1,274,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,004,000.00	1,274,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	14,627,735.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	6,649,810.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	7,977,925.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,742,000.00	23,804,000.00
210702	Дотоод албан томилолт	9,242,000.00	23,804,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	500,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,639,022.00	1,424,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	538,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	173,350.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,840.00	89,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	29,832.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	72,784,624.00	127,267,188.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,784,624.00	127,267,188.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,392,077.57</b>	<b>113,154,079.20</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	650,000.00	39,902,168.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,827,572.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	=	12,274,596.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	8,742,077.57	73,251,911.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,742,077.57	73,251,911.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>204,598,379.00</b>	<b>31,479,086.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>204,598,379.00</b>	<b>31,479,086.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>204,598,379.00</b>	<b>31,479,086.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	204,598,379.00	31,479,086.00
223001	Бусад хөрөнгө	178,824,664.00	31,479,086.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,773,715.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(204,598,379.00)</b>	<b>(31,479,086.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	470,742,769.00	128,449,985.24	1,390,614,187.37	1,989,806,941.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	14,127,268.00	14,127,268.00
C03	Дахин итгэхийг үндэслэл	470,742,769.00	128,449,985.24	1,404,741,455.37	2,003,934,209.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлээний өсөлт	0.00	-14,127,268.00	0.00	-14,127,268.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлээний бууралт	2,017,815,200.00	0.00	0.00	2,017,815,200.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	781,601,533.19	781,601,533.19
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,488,557,969.00	114,322,717.24	2,186,342,988.56	4,789,223,674.80
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,488,557,969.00	114,322,717.24	2,186,342,988.56	4,789,223,674.80
D03	Дахин итгэхийг үндэслэл	2,488,557,969.00	114,322,717.24	2,186,342,988.56	4,789,223,674.80
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	368,232,489.57	368,232,489.57
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,488,557,969.00	114,322,717.24	2,553,465,478.13	5,157,456,164.37

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны	
		Багтагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	949,329,500.00	891,192,588.80
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	916,329,500.00	859,713,502.80
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	864,774,400.00	819,811,334.80
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	650,048,400.00	629,917,238.22
210101	Үндсэн цалин	344,864,700.00	339,324,582.38
210102	Нэмэгдэл	233,551,900.00	219,737,655.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,838,000.00	19,722,000.00
210104	Урамшуулал	50,793,800.00	51,133,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	81,255,800.00	73,891,064.17
210201	Тэтгэврийн даатгал	55,254,300.00	51,499,632.69
210202	Тэтгэмжийн даатгал	6,500,800.00	5,950,453.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,250,100.00	2,975,376.38
210204	Ажилгүйдлийн даатгал	3,250,100.00	2,819,604.24
210205	Эрүүл мэндийн даатгал	13,000,500.00	10,645,997.16
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,620,100.00	30,538,007.41
210301	Гэрэл, цахилгаан	19,617,300.00	18,535,487.41
210302	Түлш, халаалт	12,002,800.00	12,002,520.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,289,600.00	22,353,300.00
210401	Бичиг хэрэг	3,441,000.00	3,433,118.00
210402	Тээвэр, шатахуун	15,130,000.00	14,364,350.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,800,000.00	1,638,000.00
210406	Бага үнэтэй, турган элэгдэх, ахуйн эд зүйлс	2,918,600.00	2,917,832.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,401,400.00	1,274,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401,400.00	1,274,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,982,000.00	14,627,735.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	6,649,810.00
210604	Урсгал засвар	7,982,000.00	7,977,925.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	24,315,500.00	23,804,000.00
210702	Дотоод албан томилолт	24,315,500.00	23,804,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,325,400.00	1,424,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	360,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	342,300.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,100.00	89,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	141,600.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,080,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	177,400.00	-

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	35,536,200.00	21,980,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,536,200.00	21,980,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51,555,100.00	39,902,168.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,555,100.00	39,902,168.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	27,000,000.00	26,827,572.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,782,000.00	12,274,596.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,773,100.00	800,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,000,000.00</b>	<b>31,479,086.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	33,000,000.00	31,479,086.00
223001	Бусад хөрөнгө	33,000,000.00	31,479,086.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	949,329,500.00	891,192,588.80
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	949,329,500.00	891,192,588.80
132005	Орон нутгийн төсвөөс	916,329,500.00	891,192,588.80
132004	Оны эхний үлдэгдэлээс санхүүжих /орон нутаг/	33,000,000.00	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	26	21
620001	Удирдах ажилтан	6	5
620002	I үйлцртгэх ажилтан	11	8
620003	Үйлчлэх ажилтан	9	8

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Омнөх он	Гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	98,250,680.00	56,637,288.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,250,680.00	56,637,288.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,250,680.00	56,637,288.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,250,680.00	56,637,288.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,250,680.00	56,637,288.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	98,250,680.00	56,637,288.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,250,680.00	56,637,288.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан ханлив, тусламж	-	120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98,250,680.00	31,116,294.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	25,400,994.00

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 79,609.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

**Залруулсан алдаа:**

- Нийгмийн даатгалын шимтгэлийн 5,257.6 мянган төгрөгийн өглөгийг бүртгэл, тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-т "бүх өр төлбөр"-ийг гэснийг зөрчсөн, УСНББОУС-19, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- "Хүүхэд эрдэнэ" хүүхэд хамгааллын төслийн хүрээнд хүлээн авсан 1,100.0 мянган төгрөгийн 3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС-17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

- Тайлант хугацааны санхүүжилтийг төвлөрүүлэх шилжүүлгийн 73,251.9 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийн санхүүгийн тайланд хасах дүнтэй тусгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, ...." гэж заасныг баримтлан ажиллаагүй байна.

Аудитаар нийт 15,485.2 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6,561.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 2,252.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6,671.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

### 3.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад 424.0 мянган төгрөгийг хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын шаардлагыг хангаагүй хууль эрх хариуцсан мэргэжилтэнд 5-н жилийн тэтгэмж 6,137.3 сая төгрөгийг олгосон байна.

### 3.2 Албан шаардлага

Цалингийн зардлаас улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,252.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Өмнөх оноос дамжин ирсэн шүүхийн шийдвэртэй холбоотой үүссэн 6,671.9 мянган төгрөгийн авлага байна.

**Өгсөн зөвлөмж:** Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ." гэж заасны дагуу байгууллагыг хохиролгүй болгох.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд 7 дугаар сард 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд мэдээллийг бүрэн Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулж байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг бүртгэл тайланд тусгаагүй	1	5,257.6			1	5,257.6					-	--	-
3 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүртгэл тайланд тусгаагүй	1	1,100.0	1	1,100.0							--		-
санхүүжилтийг төвлөрүүлэх шилжүүлгийн мянган төгрөгөөр бууруулах бичилт хийн санхүүгийн тайланд хасах дүнтэй тусгасан	1	73,251.9	1	73,251.9									
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>79,609.5</b>	<b>2</b>	<b>74,351.9</b>	<b>1</b>	<b>5,257.6</b>					-	-	--

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан олгосон	1	424.0	1	424.0									-
Цалингийн зардаас улирлын үр дүнгийн	1	2,252.0			1	2,252.0							-

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

урамшуулалт ай давхардуулан 2,252.0											
журмын шаардлагыг хангаагүй мэргэжилтэнд 5-н жилийн тэтгэмж олгосон	1	6,137.3	1	6,137.3							
Өмнөх оноос дамжин ирсэн шүүхийн шийдвэртэй холбоотой үүссэн 6,671.9 мянган төгрөгийн зєлєгє бєйнє.	1	6,671.9				1	6,671.9				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>15,485.2</b>	<b>2</b>	<b>6,561.3</b>	<b>1</b>	<b>2,252.0</b>	<b>1</b>	<b>6,671.9</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна	1	0.0	-	-	-	-	1	0.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0.0</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>								



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 13/АА160505

Чойбалсан хот

ДАА-2025/140/НА-СГА-ТМС

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулан 424.0 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "..., ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан тооцож олгосон 424,000.00 /Дөрвөн зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батсэнгээ, нягтлан бодогч Г.Гандолгор нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



И.СЭМЖИДМАА  
Д.НАРМАНДАХ

2125050032



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 02/04 / 01160905

Чойбалсан хот

2025-02/04/НА-СА-ТНБ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албаны тусгай шалгалтад 2021 онд тэнцэн, 2022 онд томилогдсон хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэнд 5-н жилийн тэтгэмж 6,137.3 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно", 43.3.4-д "..., эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх", 43.6-д "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно", Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь "Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно", 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.1-д "Сум болон ... Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан албан тушаалд томилогдон тасралтгүй 5 жил (60 сар), түүнээс дээш хугацаагаар ажилласан төрийн захиргааны албан хаагч мөнгөн урамшуулал авна" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

2125050035

1. "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын шаардлага хангаагүй мэргэжилтэнд 5-н жилийн тэтгэмжид олгосон 6,137,295.00 /Зургаан сая нэг зуун гучин долоон мянга хоёр зуун ерэн таван/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батсэнгээ, нягтлан бодогч Г.Гандолгор нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР



Д.НАРМАНДАХ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 28/АМБ0305

Чойбалсан хот

ААА-2025/140/НА-СА-П45

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 2,252.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Чойбалсан сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батсэнгээ, нягтлан бодогч Г.Гандолгор нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ



2125040006